



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/01-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2025 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.03.25 № 162  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА В.МӨНХБАТ  
ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Хайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1.Хоршоо хөгжүүлэх сангийн 12,750.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд сумын төсвийн 19 нэр төрлийн орлогоор 547,884.8 мянган төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 739,965.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөө нийт дүнгээр 134.7 хувиар давж биелжээ.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл

урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,795,217.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,318,985.8 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 476,231.5 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хайрхан сумын Засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 79.3 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	781,617.0	1,060,642.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	384,872.3	732,660.6
33	АВЛАГА	310,889.8	185,066.6
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	85,854.9	142,915.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,768,367.3	3,115,292.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,768,367.3	3,115,292.1
39200	Биет хөрөнгө	2,751,146.1	3,097,741.8
39300	Биет бус хөрөнгө	17,221.2	17,550.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,549,984.3	4,175,934.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,196.0	103,665.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,196.0	103,665.2
41300	Өглөг	54,196.0	103,665.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,495,788.3	4,072,269.2
51	Засгийн газрын хувь оролцоо	3,495,788.3	4,072,269.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	450,071.4	450,071.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,498,384.3	3,074,865.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,332.5	547,332.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,549,984.3	4,175,934.4

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,001,551.4	3,425,011.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	425,150.0	726,392.6
110	Орлогын албан татвар	279,778.2	599,615.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,688.2	599,368.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	90.0	247.5
113	Хөрөнгийн албан татвар	61,425.1	80,649.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,946.6	46,127.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	923,872.2	800,394.1
120	Нийтлэг татварын бус орлого	923,872.2	800,394.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,652,529.3	1,898,224.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,948,913.8	2,575,334.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,948,913.8	2,575,334.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,534,918.1	2,515,191.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,932.8	647,946.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,049.5	80,544.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,028.7	898,765.6
2104	Хангамж, бараа материалын зардал	46,475.0	81,116.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200.0	48,612.6
2107	Томилолт, зочны зардал	5,873.4	5,949.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	642,132.4	383,551.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,226.4	368,705.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,413,995.7	60,143.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,052,637.7	849,676.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	358,288.5	273,195.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	694,349.2	576,480.9

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,468,232.7	3,071,243.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	425,150.0	726,392.6
110	Орлогын албан татвар	279,778.2	599,615.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,688.2	599,368.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	90.0	247.5
113	Хөрөнгийн албан татвар	61,425.1	80,649.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	83,946.6	46,127.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,153.0	29,305.2
1181	Газрын төлбөр	42,891.9	6,576.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,901.7	10,246.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	390,553.4	446,626.5
120	Нийтлэг татварын бус орлого	390,553.4	446,626.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,652,529.3	1,898,224.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,863,130.6	2,316,377.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,863,130.6	2,316,377.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,449,134.9	2,256,234.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,672.7	721,874.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,731.7	106,583.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,021.0	935,198.1
2104	Хангамж, бараа материалын зардал	134,554.2	226,151.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000.0	51,972.6
2107	Томилолт, зочны зардал	5,873.4	5,949.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,217.6	53,916.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,064.2	154,587.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,413,995.7	60,143.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	605,102.1	754,866.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	387,422.4	407,077.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	387,422.4	407,077.9
2200	Дотоод эх үүсвэрээр	387,422.4	407,077.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-387,422.4	-407,077.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	217,679.7	347,788.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	167,192.6	384,872.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	384,872.3	732,660.6

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,805,799.1	2,805,799.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,360.0	-4,360.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,801,439.1	2,801,439.1
9	Тайлант үеийн үр дүн	694,349.2	694,349.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,495,788.3	3,495,788.3
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,495,788.3	3,495,788.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,495,788.3	3,495,788.3
19	Тайлант үеийн үр дүн	576,480.9	576,480.9
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,072,269.2	4,072,269.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,795,217.3	2,318,985.8	476,231.5	83.0
УРСГАЛ ЗАРДАЛ	2,246,053.5	1,971,216.9	274,836.6	87.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,177,427.4	1,911,073.8	266,353.6	87.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,921.5	646,812.9	88,108.6	88.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,865.2	80,544.1	11,321.1	87.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,058,737.5	898,765.6	159,971.9	84.9
Хангамж, бараа материалын зардал	64,814.0	63,846.7	967.3	98.5
Эд хогшил, урсгал засварын зардал	100,326.0	99,082.6	1,243.4	98.8
Томилолт, зочны зардал	6,230.0	5,949.6	280.4	95.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,361.1	15,588.8	772.3	95.3
Бараа үйлчилгээний бусад зардал	104,172.1	100,483.5	3,688.6	96.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,626.1	60,143.1	8,483.0	87.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	15,750.0	15,750.0	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	52,876.1	44,393.1	8,483.0	84.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	413,763.8	347,768.9	65,994.9	84.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	135,400.0	-	135,400.0	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,795,217.3	2,493,574.3	301,643.0	89.2
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,366,799.9	2,382,811.1	(16,011.2)	100.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	428,417.4	110,763.2	317,654.2	25.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		149,309.5	(149,309.5)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		323,898.0	(323,898.0)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	26	26		100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26		100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,808.9
УРСГАЛ ЗАРДАЛ	78,808.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,787.9
Хангамж бараа материалын зардал	2,050.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,934.5
Бараа үйлчилгээний бусад зардал	65,803.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,808.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	78,808.9

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй. Харин залруулагдаагүй нийт 12,750.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 1 зөвлөмж хүргүүлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн 12,750.0 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **50,734.6** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг гэж үнэлснээр нийт материаллаг зөрчлийн дүн **65,484.6** мянган төгрөг болсон. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **21,859.2** мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 3.1 Зөвлөмж

##### 3.1.1 Авлагатай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд зээл олгосон "Хөгжлийн түүчээ" хоршооны 2024 онд төлөх үндсэн төлбөр 12,750.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь тайлант хугацаанд хамаарах хугацаа хэтэрсэн зээл ангилалд орсон байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 10 дугаар зүйлийн 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Зөвлөмж:** Хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч авлагыг барагдуулах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХС	1	12750.0					1	12750.0				
Нийт дүн	1	12750.0					1	12750.0				

### 4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ИТХ /Хязгаарлалттай дүгнэлт /	5	18582.4	1	875.5	4	17706.9						
ЗДТГ /Хязгаарлалттай дүгнэлт /	5	32152.2	2	2246.4	3	29905.8						
Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ /Хязгаарлалттай дүгнэлт /	6	181236.3	-	-	6	181236.3						
Нийт дүн	16	231970.9	3	3121.9	13	228849.0						

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	0	1	0				
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	0	1	0				